



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот

Г Төслийн удирдах хороо
байгуулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусlamж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 9.1.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан хоорондын хамтын ажиллагааны тухай үндсэн хэлэлцээрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжих “Монгол Улсад хэрхийн шалтгаант хүүхдийн зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах нь” төслийн хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий Төслийн удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Удирдах хорооны ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. “Монгол Улсад хэрхийн шалтгаант хүүхдийн зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах нь” төслийн удирдах хорооны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу удирдлага зохион байгуулалтаар хангаж, бодлогын чиглэлийн дагуу хяналт тавьж ажиллахыг Удирдах хорооны дарга /С.Төгсдэлгэр/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар /С.Сүнчин/-т үүрэг болгосугай.

САЙД

S.ЧИНЗОРИГ

С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын 2023
оны 09. сарын 20-ны өдрийн
A/65 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт

**“МОНГОЛ УЛСАД ХЭРХИЙН ШАЛТГААНТ ХҮҮХДИЙН ЗҮРХНИЙ ӨВЧНӨӨС
СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ” ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮН**

- Дарга: Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Дэд дарга: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч
- Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж үйлчилгээний газрын Анхан болон лавлагаа шатлалын тусlamжийн хэлтсийн Хүүхэд, өсвөр үеийн тусlamж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сангийн ажилтан
- Гишүүд: Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж үйлчилгээний газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга;
- Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга;
- Улсын гуравдугаар төв эмнэлгийн Зүрх судасны үндэсний төвийн захирал;
- Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн тусlamж хариуцсан дэд захирал;
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга;
- Люксембургийн Хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн төлөөлөл;

Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газрын дарга /зөвшилцсөнөөр/;

Монголын өрхийн анагаахын мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл /зөвшилцсөнөөр/;

Ажиглагчид:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Зүрх судасны тэнхимийн төлөөлөл /зөвшилцсөнөөр/;

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн төлөөлөл

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
02 сарын 20 -ны өдрийн 115
дугаар тушаалын хоёрдугаар
хавсралт

**“МОНГОЛ УЛСАД ХЭРХИЙН ШАЛТГААНТ ХҮҮХДИЙН
ЗҮРХНИЙ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ“
ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ АЖЛЫН УДИРДАМЖ**

Үндэслэл

“Монгол Улсад хэрхийн шалтгаант хүүхдийн зүрхний өвчнөөс сэргийлэх, түүнийг бууруулах” төсөл нь монголын хүүхэд, өсвөр үе ялангуяа эмзэг бүлгийн хүүхдэд эрүүл мэндийн олон талт, харилцан уялдаа бүхий үйлчилгээ үзүүлснээр тэдний амьдралын чанарыг сайжруулах зорилготой үндэсний хэмжээний төсөл юм.

Нэг: Зорилго

- 1.1. Төслийн хэрэгжилтэд бодлого, стратегийн чиглэл өгч, ерөнхий хяналт удирдлагаар хангах;
- 1.2. Төслийн үйл ажиллагаа үндэсний бодлого, стратегитай нийцэж буй эсэхэд хяналт тавьж, төлөвлөсөн арга хэмжээнүүдийн уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулж, үйл ажиллагааны давхардлыг багасгах.
- 1.3. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, хөгжлийн түншүүд болон Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ) (эмэгтэйчүүд, залуучууд, хүүхдийн байгууллага гэх мэт) зэрэг бусад оролцогч талуудтай хамтын ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр: Удирдах хорооны чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт

- 2.1. Удирдах хороо нь дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Дарга нь Эрүүл мэндийн сайдаас томилсон эрх бүхий албан тушаалтан байх ба Дэд дарга нь НҮБ-ын Хүүхдийн сангийн Суурин төлөөлөгч байна.
- 2.2. Удирдах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь удирдах хорооны хурал байна.
- 2.3. Удирдах хороо нь 6 сар тутам хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зэлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. Хурлын товыг Эрүүл мэндийн яам ба Люксембургийн Засгийн газартай зөвшилцөнө. Удирдах хорооны хурлыг гишүүдийн олонх буюу 60 /жар/ хувиас дээш ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд аливаа

асуудлыг хуралд оролцож буй гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.4. Удирдах хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралд биечлэн оролцох боломжгүй бол Нарийн бичгийн даргад мэдэгдсэний үндсэн дээр төлөөлөл томилон оролцуулах, эсхүл хурлаас өмнө саналаа бичгээр өгсөн тохиолдолд хурлын ирцэд оруулан тооцно.

2.5. Шаардлагатай тохиолдолд удирдах хорооны хуралд бусад олон улсын байгууллага, хандивлагчид болон техникийн туслалцааны агентлагуудын төлөөллийг ажиглагчаар урьж оролцуулж болно.

2.6. Удирдах хороо нь өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд төлөвлөгөөг нэг жилээр гаргана.

2.7. Хурал бүрийн эхэнд зорилго, хэлэлцэх асуудлыг гишүүдэд тодорхой танилцуулж, эцэст нь санал дүгнэлт, шийдвэр гарсан байна.

2.8. Удирдах хорооны хурлыг дарга удирдана.

2.9. Даргын эзгүйд дэд дарга эсвэл түүний эрх олгосноор гишүүн удирдана. НҮБ-ын Хүүхдийн сангийн мэргэжилтэн, төслийн удирдагч нар дэд даргын үүргийг орлон гүйцэтгэхгүй.

2.10. Удирдах хорооны хурлаар төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан хянан баталж, тайланг хэлэлцэн баталгаажуулна.

2.11. Удирдах хорооны дарга нь Эрүүл мэндийн сайд, бусад холбогдох талуудад төслийн явцыг тайлagnана. Танилцуулгыг нарийн бичгийн дарга /хариуцсан мэргэжилтнүүд/ бэлтгэж өгнө.

2.12. Удирдах хорооны нарийн бичгийн дарга хурлын тов, хэлэлцэх асуудлыг боловсруулан, даргаар батлуулж, хурлын урилга болон хэлэлцэх асуудлыг гишүүдэд ажлын 3-5 хоногт багтаан хүргүүлж, хурлын тэмдэглэл хөтөлнө.

2.13. Удирдах хороо нь үндэсний болон олон улсын стратеги, хөтөлбөр төслүүдтэй хамтын ажиллагааг уялдуулан, нийцүүлэх, салбарын бодлоготой нягт нийцүүлэх зохицуулалтыг хангаж ажиллана.

2.14. Удирдах хорооны дэд дарга дараах асуудлыг хариуцна:

2.14.1. Хурлын хэлэлцүүлэгт гишүүдийн оролцоог хөхиүлэн дэмжиж, идэвхтэй оролцоог хангана.

2.14.2. Удирдах хорооны гишүүд хуралд хүндэтгэж үзэх шалтгаангүйгээр 2-оос дээш удаа тасалсан тохиолдолд хорооны бүрэлдэхүүнээс хасаж, оронд өөр гишүүн оруулах асуудлаар санал оруулах эрхтэй байна.

2.14.3. Удирдах хорооны хурлаар нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй тохиолдолд санал хураалтыг зохион байгуулж ажиллана.

Гурав. Удирдах хорооны хурлын шийдвэрүүд

3.1. Удирдах хорооны гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Хуралд оролцоогүй ч зохих зөвшөөрлийн үндсэн дээр гишүүн байгууллагын бичгээр ирүүлсэн санал хүчин төгөлдөр байна.

3.2. Удирдах хорооноос гаргасан шийдвэр нь тэмдэглэл хэлбэртэй байна.

3.3. Удирдах хорооны шийдвэрийг үндэслэн, засгийн газрын байгууллагууд, албан тушаалтууд батлагдсан жилийн ажлын төлөвлөгөө, зохих дүрэм журмын дагуу өөрсдийн эрх хэмжээ, үүрэг хариуцлагын хүрээнд шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

3.4. Нарийн бичгийн дарга нар хурлын тэмдэглэлийг хөтөлж, шийдвэрийн төсөлд гишүүдийн саналыг тусган удирдах хорооны даргаар албажуулах үүрэг хүлээнэ.

3.5. Бүх гишүүд хуралд идэвхтэй оролцож санал зөвлөмж өгөх ба удирдах хорооны хурлаас гаргасан шийдвэрийн өмнөөс хамтын хариуцлага хүлээнэ.

3.6. Удирдах хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны бүрэлдэхүүнд нэмэлтээр гишүүн оруулах эсхүл хасах санал гаргаж болно.

3.7. Удирдах хорооны гишүүд энэхүү удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно.